

Ж.Гэлгее

Владивостокийн  
чуулга: Зүүн хойд азийн  
интеграци руу юу?...

Л.Дашпүрэв

Үндэсний ашиг  
сонирхолын онол,  
практикийн асуудалд

Б.Санжмятав

Хөгжлийн бодлого  
прагматик болж  
байгаа нь

# БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2018.10 №9



Бодлогын судалгааны төв  
Монгол Улсын Их Сургууль  
Олон Улсын Харилцаа,  
Нийтийн Удирдлагын Сургууль

## РЕДАКЦИЙН ЗУРВАС

01 Намар

## БҮС НУТАГ

02 Владивостокийн чуулга: Зүүн хойд азийн интеграци руу юу?...

## ОЛОН УЛСАД

04 America's global engagement

## ОНОЛ, ПРАКТИК

06 Үндэсний ашиг сонирхолын онол, практикийн асуудалд

## ОНЦЛОХ СЭДЭВ

09 Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы нээлтэд /10.01/ Ерөнхийлөгч Х.Баттулга оролцож хэлсэн үгнээс.


10 Хөгжлийн бодлого прагматик болж байгаа нь

Дугаарыг эрхлэн бэлтгэсэн:

Х.Бэхбат

Эх бэлтгэгч:  
Хэвлэсэн газар:

Х.Балдандорж  
"Удам Соёл" ХХК



Намар

Навчис шаргалтаж анхны цас унах цагаар ажил алба ч эргэн эрчимжих аж.

Хурим найрын зэрэгцээ хурал цуглааны тоо эрс олширов. Өвлийг “өнтэй өнгөрүүлэх” бэлтгэл олон утгаар эхлэв бололтой.

Манай дотоод улс төр намжуу юмуу гэтэл улам адармаатай болохыг УИХ-ын намрын чуулганы эхний өдрүүд харууллаа. Эдийн засаг өсөж буй харагдавч үргүйдүүлэгч үзэгдлүүд хүчтэй хэвээр... Харин Ерөнхий сайд АНУ-д зочилж, НҮБ-ын ЕА-н чуулганд оролцож үг хэлсэн нь анхаарал татахуйц ажээ.

Олон улсын байдал, төлөв урьдчилан харсанаас төдийлэн зөрсөнгүй гэлтэй. Гурван “томын” сөргөлдөөн гүнзгийрсэн хэвээр. Цэрэг зэвсэгт дулдуйдах бодлого хааяагүй үргэлжилнэ. Гэвч эрүүл саруул гэмээр үг яриа, үйлдэл цөөрөөгүй байгааг ажиглаж болно.

Манай ЗХА-д, тухайлбал солонгосын асуудал нэг урагшилж, нэг ухарч, дороо хий эргэсээр авч найдвар тасраагүй байна. Найдвар хамгийн сүүлд бөхдөг гэдэг бил үү.

Х.Бэхбат

\* \* \*

-The most perfect political community is one in which the middle class is in control, and outnumbers both of the other classes.

-The society that loses its grip on the past is in danger, for it produces men who know nothing but the present, and who are not aware that life had been, and could be, different from what it is.

Aristotle

-You can do a lot more with weapons and politeness than just politeness.

Vladimir Putin

-North Korea will never give up its arsenal. It's all that is keeping us alive. We are a nuclear power. That is not negotiable. We are willing to talk about limits freezes - but we would need to be given something in return security, in the form of diplomatic recognition by Washington and guarantees of nonaggression from China, Japan and the United States.

Kim Jong-un



Ж.Гэлгээ

Олон улсын эдийн засагч, доктор (PhD)

# ВЛАДИВОСТОКИЙН ЧУУЛГА: ЗҮҮН ХОЙД АЗИЙН ИНТЕГРАЦИ РҮҮ ЮУ?...

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины ивээл дор үүссэн “Дорнын эдийн засгийн чуулга” 4 дэх удаагаа Владивосток хотноо өнгөрсөн 9 дүгээр сарын аравдаар 3 хоног болж өнгөрөв. Чуулгад 60 гаруй орноос 6000 гаруй хүн хүрэлцэн ирсэн нь цар хүрээ нь өргөжсөөр буйг илтгэнэ.

Зүүн хойд Азийн 6 улсад манай гаригийн хүн амын 23%, ДНБ-ий 19% ногддог бөгөөд 2018 оны уулзалтад 5 улсынх нь төр, засгийн тэргүүн оролцсоноос үзэхэд глобал даяаршлын хүрээнд бүс нутгуудын интеграци илүү хурдацтай хөгжих зүй тогтол Зүүн хойд Азид ч ажиглагдаж эхлэв үү гэлтэй. Хөрсөн дороо эрдсийн арвин баялагтай, ой модоор өвч бүрхэгдсэн, онгон хэвээрээ байгаа ОХУ-ын Алс Дорнодын өргөн уудам нутаг дурдсан интеграцийн үйл явцад чухал талбар болох боломжтой юм.

Чуулгад БНХАУ-ын дарга Ши Жинпин анх удаагаа хүрэлцэн ирсэн нь олон улсын харилцааны төрх байдлаас юун түрүүнд үүдэлтэй бололтой. Тэрээр нэгдсэн хуралдаан дээр

“хувиа хичээсэн, протекционист” хандлага газар авах төлөвтэй болж буй өнөөгийн нөхцөлд “ЗХА-ийн улс орнууд хөгжлийн стратегиа авцалдуулж, хил дамнасан дэд бүтцээ бэхжүүлэн, худалдаа, хөрөнгө оруулалтаа либералчлах”-ыг уриалсан байна. Алс Дорнод дахь Орос-Хятадын эдийн засгийн хэлхээ холбоо нь гол төлөв нефть болон хий дамжуулах мега төслүүдэд чиглэж ирсэн бол цаашид дэд бүс нутгуудаа түлхүү оролцуулах бололтой. Энэ намрын уулзалтад Хятадын 8 мужийг төлөөлсөн 1000 гаруй хүн, Оросын 13 субъектын төлөөлөгчид оролцсон байна.

Японы Ерөнхий сайд Ш.Абэ чуулгад жил дараалан оролцож буй зорилго нь нь, түүний цохон тэмдэглэсэнчлэн “энх тайванч, эрчимтэй цэцэглэн хөгжиж буй, эрх чөлөөт, шударга засаглал бүхий Хятад, БНСУ, Монголыг нэгтгэсэн Зүүн хойд Азийг дэлхийн тайзнаа товойн гарч ирэх”-эд дэмжлэг үзүүлэх аж. “Зөрчлийн талбар болж ирсэн арлууд төдөлгүй тээвэр-ложистикийн төвүүд болон хувирч Япон-Оросын найрсаг харилцааны бэлгэдэл болно”

гэдэгт итгэлтэй байгаагаа тэрээр мөн тэмдэглэсэн. Алс Дорнодод газрын тос, байгалийн хий зэрэг эрчим хүчний түүхий найдвартай эх үүсвэртэй болох нь Японы тухайд нэн чухал нь ч ойлгомжтой.

Өмнөд Солонгосын Ерөнхий сайд Ли Нак-ён Владивостокт дараагийн удаа галт тэргээр ирнэ гэж мэдэгдэв. Солонгосын хоёр хэсгийг холбосон төмөр зам биет байдлаараа бэлэн ч олон улсын хоригийн улмаас сул зогссон хэвээр, гэхдээ түүнийг ажиллагаанд оруулах цаг мөд гэдгийг бэлгэдсэн үг юм. Алс Дорнод нь Орос-Солонгосын харилцааны үндсэн дөрвөн талбарын нэг нь болохыг тэмдэглэхийн сацуу Хойд болон Өмнөдийг хамарсан гурван талт харилцааг дэмжихэд эл бүс нутаг нэн чухлыг онцоллоо. Өмнөд Солонгосоос бизнесийн 200 гаруй төлөөлөл ирж Оросын бизнесийнхэнтэй тусгайлсан салбар хуралдаан зохион байгуулав. Байгалийн хий, төмөр болоод усан замын тээвэр Алс Дорнод дахь аж ахуйн харилцаанд тэргүүлэх салбар болох тухайд тэд санал нэгджээ.

ЗХА-ийн хамтын ажиллагаанд



оролцох нь Монголын тухайд эдийн засгийн төдийгүй улс төрийн ч ач холбогдолтой. Япон, Өмнөд Солонгос гэсэн гуравдагч хөрштэйгөө суудал зэрэгцэн хил залгаа 2 том гүрэнтэйгээ нэг зиндаанд асуудлыг шүүн хэлэлэх боломж гарч буй хэрэг. Оросын хийгээд Хятадын боомтуудын зэрэгцээ Солонгосын хойгоор дамжин их далайд гарах гуравдахь чиглэл бий болох боломжтой. Хоёр хөршийн аль алиных нь нутгаар дамжин Хойд болон Өмнөд Солонгос руу төмөр болон авто замын тээвэрлэлт хийх нөхцөл ч бүрдэнэ. Алс Дорнод дахь эдийн засгийн идэвхжил нь “Их түмэн гол” санаачилгын хүрээнд дэх төслүүдийг урагшлуулахад дам нөлөө үзүүлнэ. Чингэхлээр Монголын тухайд ДЭЗ чуулгад оролцох нь АПЕК, АСЕАН зэрэг бүтцийн уулзалт хэлэлцээнд оролцохоос ч илүү практик ач холбогдолтой.

Ийм ч учраас манай Ерөнхийлөгч жил дараалан Владивостокийн уулзалтад очиж холбогдох төслүүдэд дэмжлэг авах чиглэлээр ажиллалаа. Энэ жилийн чуулгад Монголоос

60 шахам ажил хэрэгч хүмүүс оролцсон нь сайшаалтай.

Сибирийн байгалийн хийг Хятадын төв хэсэг рүү дамжуулах хоолойг Монголын нутгаар дайруулан тавих талаар манай Ерөнхийлөгчийн хүсэлтэд В.Путин нааштай харну өгсөн. Өмнөд хөршийн төрийн өмчийн холбогдох компаниуд ч эл төслийг судлах, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж эхлэсэн мэдээ бий. Хэдийвээр энэ төслийг хэрэгжүүлэх ажлууд Гурван улсын эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хүрээнд голчлон хийгдэх ёстой ч бүс нутгийн томоохон хөршүүдийн анхаарлыг бас хандуулж байхад гэмгүй. Хамгийн гол нь манай төр засгийнхан, улс төрчид нэгдмэл байр суурьтай байж, нөхцөл болзлоо анхнаас нь тогтвортой байлгах ёстой. Чингэвэл хямдхан хий ашиглах нөхцөл ч бүрдэнэ, транзит шугамын төлбөрийг төсөвтөө нэмэрлэх боломж ч нээгдэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хөндөж ярьсан дараагийн төсөл “Азийн супер сүлжээ”. Монголын их говийн нар, салхины эрчмийг

цахилгаанд хувирган Хятадын нутгаар дамжуулан Солонгосын хойг, Японы аралд хүргэх энэ төсөл нь экологийн хувьд цэвэр гэдгээрээ давуу талтай. Японы SB Energy Corp, хятадын State Grid Corp of China (SGCC), солонгосын Korea Electric Power Corp (KEPCO) болон оросын Russian Electric Power and Grid Operator (Rosseti) 2016 оны 3 дугаар сард Бээжин хотноо Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж ТЭЗҮ-г нь боловсруулахаар тохиролцоод буй. ЗХА-д түншлэгч орнуудын төр, засгийн түвшинд ажлын хэсэг бий болгох талаарх манай Ерөнхийлөгчийн санал энэ төсөлд түлхэц болох нь дамжиггүй.

Цар хүрээгээрээ дэлхийд эхний 15-ын дотор багтдаг 4 эдийн засаг бүхий ЗХА-ийн Алс Дорнод дахь хамтач ажиллагаа нь уул тал, ус далайгаар хаяа нийлэн орших энэ бүс нутгийг интеграци руу хөтлөн буй нэгэн шижим бөгөөд бидний монголчууд ч түүнтэй алхаа гишгээгээ нийлүүлэх учиртай биз ээ.

By George Friedman

# AMERICA'S GLOBAL ENGAGEMENT

The myth of disengagement derives from American rhetoric and not American actions.

I am writing this from Budapest, where Corvinus University has been kind enough to invite me to be a distinguished international fellow. (Having been a university instructor decades ago, I can confidently say being a distinguished international fellow is much nicer.) Since arriving in Budapest, I have been repeatedly asked why the United States is disengaging from the world. I have heard this said by some Americans as well, but my response is always the same: The United States continues to be deeply engaged in the world, and the myth of disengagement derives from American rhetoric and not American actions.

Take [the renegotiation of NAFTA](#) for example. The United States is involved in [discussions with Mexico and Canada](#) over the future of continental trade. Let this be regarded as a trivial relationship, the total population of North America is about 500 million, roughly the same as the European Union. The combined gross domestic product of these three countries is roughly that of the combined GDP of EU members. So the redefinition of this trade relationship is as complex and difficult as such a

negotiation would be in Europe.

The United States is also trying to redefine its trade relationship with China. It recently imposed tariffs on a large number of Chinese imports to the U.S., arguing that China has engaged in unfair trade practices through currency manipulation, barriers to U.S. exports and so on. China has responded with tariffs of its own.

Meanwhile, the United States remains on alert over North Korea. The North Koreans appear to be backing away from commitments to denuclearize, and the possibility that this will extend to deploying intercontinental ballistic missiles capable of striking the United States has not evaporated. U.S. aircraft remain poised on Guam, approximately 30,000 U.S. troops are deployed in South Korea, and naval assets are available. War is not near, but it is still possible, and [more talks are being considered](#).

At the same time, [U.S. vessels are periodically conducting freedom of navigation operations in the South China Sea](#) to challenge Chinese territorial claims. The U.S. has also backed Australia and New Zealand's attempts to [limit China's economic leverage](#)

[over South Pacific island nations like Tonga](#).

This is part of a [broader attempt to limit Chinese power](#) in the region that also includes the Quadrilateral Security Dialogue, an alliance that lays the groundwork for cooperation between Japan, Australia, India and the U.S. In the past, the four nations have conducted, in different configurations, naval exercises in the Western Pacific, and the United States, Japan and Australia seem to want to formalize the military aspect of the alliance. (India is prepared to cooperate on an ad hoc basis, but not as part of a formal military alliance.) U.S. Secretary of Defense James Mattis is visiting India this week, and talks on the Quad are likely to take place. In addition, the United States and Vietnam have taken significant steps to coordinate their military and security efforts, focusing on China.

In South Asia, the United States is engaged in negotiations with the Taliban to bring [the 17-year war in Afghanistan](#) to some sort of conclusion. There have been secret talks in the past, but the current negotiations are quite open and coincide with

a repositioning of U.S. troops away from offensive operations. These talks are complex and will inevitably involve Pakistan. Not incidentally, Mattis will also be visiting Pakistan this week.

To the west, the United States is trying to refine a strategy on Iran. Owing to the U.S. failure to pacify Iraq, the Iranians have a powerful hand there, as well as in Syria, Lebanon and Yemen. The spread of Iranian power is of greater significance than Iran's nuclear program, as it is a far more immediate threat. The U.S. is increasing its support for anti-Iranian forces in Iraq, as well as for [Kurdish groups in Iran](#) and Iraq. The U.S. is tangled in relations with Israel, which is challenging Iran in Syria, and with the Saudis and United Arab Emirates, both of which are involved in Yemen. The situation is made even more complicated by the weakening of the Iranian economy and the rise of some degree of public opposition in Iran.

Then there's the United States' relationship with Turkey. Turkey is attempting to play the U.S. and Russia against each other, and threatening to [limit its relations with Washington](#) in favor of Moscow. Given the long history of tensions between Turkey and Russia, and the fact that in any entente with Moscow Ankara would be the weaker player, the U.S. tends to disregard this. Nevertheless, the U.S. hit the Turks with new tariffs on exports a few weeks ago, at a time [the Turkish currency was in decline](#). The U.S. is now using tariffs as a tool to shape political relations, but Turkey has not yet taken steps to break with the United States.

In Europe, the U.S. has stationed troops, aircraft and other assets in Poland and Romania. The likelihood of a Russian attack is low; the Russians have retreated to the Ukrainian border in the south, and they know that an attack in the north would rapidly involve U.S. forces. Those forces may be insufficient to stop a full-blooded Russian attack, but they are part of a strategy Washington also deployed during the Cold War. The U.S. had a brigade in West Berlin that wasn't large enough to stop a Russian assault, but the Russians understood that attacking and killing American troops would bring a massive and unpleasant response.

This list of very current activities demonstrates that the U.S. is far from disengaged in the world. But it is disengaged from Germany and Western Europe simply because no U.S. interest is threatened there at this time, and these countries and NATO won't or can't provide substantial and strategically significant support for major U.S. interests in the Pacific. Despite U.S. engagement in Poland and Romania, the European perception is, as I will put it frankly, that [if the U.S. is not engaged with France and Germany, it is not engaged in the world](#). This is because France and Germany think of themselves as the center of the world. This is an unkind and perhaps unfair statement, but it helps to explain this strange Western European idea of American disengagement.

It is also important to note that many of these engagements are simply a continuation of older policies. The North Korean nuclear issue dates back to the

Clinton administration, which had same red lines. The Quad alliance originated in the George W. Bush administration. The relationship with Vietnam and India has been evolving through many administrations, and negotiations with the Taliban have been ongoing at least since the Obama administration. The deployment along the Russian frontier was started under George W. Bush and increased under Obama, and the crisis in U.S.-Turkish relations goes back at least to the 2016 failed coup. There are a few new developments, however – namely the use of tariffs, the NAFTA negotiations, and the need to limit Iranian expansion.

There is certainly a political battle between factions in the United States, and the atmosphere is tense. But it is noteworthy that regardless of what some might think, U.S. foreign policy has had far more continuity than disruption. The atmosphere has certainly shifted, and U.S. strategy has merely evolved. Geopolitics dictates that nations are driven in their major relations by necessity, and that has held true for the U.S.

There has long been a vast divergence between the rhetoric of politicians and American reality. The U.S. has always been difficult for many Europeans and others to understand. But then, Americans are frequently baffled by America as well. But for all the storms and stresses, the U.S. remains deeply engaged in the world. We can agree or disagree with particular actions, but the idea of disengagement has no basis in reality.

Sep.2018

\*Энэ өгүүллийг олон нийтэд хүргэхийг зохиогч нь зөвшөөрсөн болно.



Л. Дашпүрэв

Элчин сайд асан, Олон улс судлалын доктор /PhD/

# ҮНДЭСНИЙ АШИГ СОНИРХОЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛД

Улс, үндэстэн бүрийн гадаад, дотоод бодлого нь судалгаанд суурилсан, ялангуяа гадаад бодлогын салбарт өнгөрсөн, одоо, ирээдүйг харгалзан олон улсын нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, өөрийн улсын үндэсний ашиг сонирхолд тулгуурласан шийдвэр гаргах механизмыг зөв тодорхойлох, хэрэгжүүлэх явдал урт хугацааны тогтвортой хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж эрдэмтэд, судлаачид үздэг байна. Энэ утгаар авч үзвэл, юуны өмнө олон улсын харилцаан дахь өөрийн улс орны ашиг сонирхолд түлхүү анхаарах шаардлага тавигдах нь ойлгомжтой.

Дэлхийн улс орнуудын жишгийг харахад, олон улсын харилцаанд ашиг сонирхолыг **нэгдүгээрт:** үндэсний ашиг сонирхол, **хоёрдугаарт:** олон улсын ашиг сонирхол, **гуравдугаарт:** дэлхийн ашиг сонирхол гэж 3 ангилдаг. Эдгээр нь бодлого, онол, практик үйл ажиллагаа талаасаа маш өргөн хүрээтэй тул энэ удаа үндэсний

ашиг сонирхолын онол, практикийн зарим асуудлыг хөндөх нь зүйтэй гэж үзэв.

Үндэсний ашиг сонирхол / National interest / гэдэг нь тухайн төр, улсын өөрийнх нь ашиг сонирхол бөгөөд орчин үеийн дэлхийн системийн нэг үндсэн тодорхойлолт болох даяаршил болон улс орны харилцан хамаарал, дэлхийг бүхэлд нь авч үзсэн нэгдмэл байдлын асуудал юм. Олон улсын улс төрийн бодлогын үндсийг тухайн орны төр, улсын үндэсний ашиг сонирхолоор нь ойлгож болно.

Үндэсний эрх ашгийг авч үзэхэд, үндсэн хоёр ойлголт болох реализм, либерализмын тухай асуудалтай тулгардаг. Энэ хоёрын томоохон ялгаа гэвэл реализм нь аливаа орны улс хоорондын харилцааг судалгааны үндсэн төв болгон улмаар орон бүрийн үндэсний ашиг сонирхол нь их, бага хэмжээгээр олон улсын системийн хандлагыг баруун, зүүний хоёр чиглэлээр авч үзэж байхад, либерализм нь олон улсын байгууллага, төрийн

бус байгууллага / NGO / зэрэг улс орны гадаад тогтолцоог ч оролцуулан олон улсын нийтлэг чанарыг бодолцдог учраас дээр дурдсан олон улсын болон дэлхийн эрх ашиг сонирхол мөн чухал объект нь болж өгдөг байна.

Энэ асуудлыг Өрнөдийн зарим улс орон дээр авч үзэж болох юм. 19, 20 дугаар зуунд Өрнөд Европт түрэмгийллийн бодлогыг зорилгоо болгож, дэлхийн томоохон дайны үед олон орон милитаризмын ашиг сонирхолыг дээгүүрт тавьж байжээ. 20 дугаар зуун дэлхийн нэг, хоёрдугаар дайн гэх мэт хүн ардад хамгийн харгис түрэмгийллээрээ олон улсын харилцааны түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн гэж үздэг. Зарим тоо баримт, судалгаагаар 170 сая хүн үхэж үрэгдэн зөвхөн сүүлийн 13 жилд нь хүмүүс хоорондын үзэн ядалтаас болж 2 сая орчим эмэгтэйчүүд, хүүхэд, тэдний 90 орчим хувь нь зэвсэгт мөргөлдөөний улмаас үрэгдэж, шархдсан аж.

Үндэсний ашиг сонирхолыг



дээдлэх бодлого баримталж ирсэн орны хувьд АНУ идеалист үндэсний ашиг сонирхолыг хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болно. Өөрийгөө “Бурханы орон” гэх үзэл бодлоор ойлгож ирсэн. Улмаар АНУ-д “Дэлхий биднийг дагах ёстой” гэсэн Т.В. Вильсоны онол, үзэл бодол үйлчилж ирсэн бөгөөд энэ утгаар Америкийн ард түмний дийлэнхи олонхи нь өөрийн орны үндэсний ашиг сонирхолыг гаргаж тавихдаа, нийт хүн төрөлхтөний ашиг сонирхолыг хамгаалах зорилгодоо хүрч чадна гэсэн үзэл бодол давамгайлж иржээ. Гэвч энэ нь бусад улс орны өнцөгөөс харахад, уг чанартаа олон улсын эрх ашгийг хамгаалж байгаа юм шиг мөртлөө идеалист үзэлтэй АНУ-ын дэвшүүлж байдаг үнэт зүйлсийн нэг “ардчилал” юм. Ардчилсан орнууд харилцан тэмцэл хийхгүй, худалдааны илүү дотно сайн харилцаа, хамтын ажиллагаатай дипломат түнш орон болохын тулд АНУ-ын аюулгүй байдлыг хангаж, байнгын тогтвортой энх тайвныг сахин хамгаалахын төлөө байх ёстой. Хамгийн чухал стратегийн бодлого нь дэлхийн орон бүрийн ардчиллын үнэт зүйлс, хөгжлийг АНУ өөрөө дэмжих явдал юм гэж үздэг. АНУ-ын уламжлал болгон баримталж ирсэн үндэсний эрх ашгийг хамгаалах / үндсэрхэг, эх оронч үзэл гэж хэлж болох юм / энэ үзэл баримтлалыг өнөөгийн олон улсын нөхцөл байдлаас харахад, АНУ-ын Ерөнхийлөгч Д. Трамп үүнийг тууштай хамгаалж, БНХАУ болон бусад оронтой гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг / худалдааны дайн / хэрхэн явуулах, мөн Өрнөд Европ, өөрийн холбоотон

бусад улс, орнуудтай явуулж байгаа аюулгүй байдал, цэрэг, стратегийн бодлогыг Америкийн эрх ашигт нийцүүлэн эргэж харах гэх мэт дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа олон асуудлыг энд тэмдэглэх хэрэгтэй. Нөгөө талаар АНУ дэлхийн улс оронтой харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, НҮБ-ын үүрэг, ач холбогдолд “хөнгөн хийсвэр” хандаж ирсэн нь АНУ-ын хувьд эрх чөлөө, ардчилалын үнэт зүйлсийг дээдлэн олон улсын хэлхээ холбоог бий болгох, түүнийг ургаш ахиулахад сөргөөр үйлчилдэг гэсэн шүүмжлэл байдаг байна.

Эрх чөлөө, ардчилал, хүний эрх, зах зээлийн эдийн засгийн системд суурилсан АНУ-ын үндэсний ашиг сонирхол нь Америкийн олон улсын нийгэмд leadership буюу тэргүүлэх, манлайлах үүрэгтэй байх зорилготой гэж судлаачид үздэг.

Япон улсын хувьд Эдогийн үед үндэсний ашиг сонирхолтой төстэй үг хэллэг гарч, өөрийн улс орны бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон гар үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний салбар дахь улсын үйлдвэрийн бүтээгдэхүүнээр өөрийнхөө хэрэгцээг хангах үзэл санаа буюу эдийн засгийн ашиг сонирхолтой холбоотойгоор илэрч байжээ. Мейжийн эрин үед /1868 оноос/ мөн нэг адил эдийн засгийн бүтээн байгуулалтын онолыг илүүтэйгээр ашиглаж байсан бол 1960-аад оноос national interest гэсэн орчуулгатайгаар улс төрийн ашиг сонирхолд илүү анхаарах болсон байна. Мөн Япон орон хүйтэн дайны жилүүдэд дайнд хамрагдан орохгүйн тулд үндэсний ашиг сонирхолын гол

чиглэл эдийн засгийн хөгжил, цэцэглэлийн хүчин чадлыг гол зорилтоо болгож ирсэн хандлага ажиглагддаг.

Үндэсний ашиг сонирхолын тэргүүлэх чиглэл нь цаг үе, тухайн улсын үнэт зүйлс, нийгмийн систем, төрийн бодлогыг тодорхойлогчид зэргээс шалтгаалан ихээхэн ялгаатай. Ялангуяа ардчилал, зах зээлийн эдийн засагтай орнуудад олон нийт ч гэсэн гадаад харилцаа, дипломат ажиллагаанд чухал байр суурь эзэлдэг учраас улс хоорондын төдийгүй ард түмний санал сэтгэгдлийг тооцож үзэх явдал чухал байдаг. Гэвч гадаад бодлого, үйл ажиллагааны стратеги нь улс орны дотоод нөлөөлөх учраас улс орондоо эзэн болж байгаа хэн боловч эрх ашгаа хамгаалахтай холбоогүйгээр ард түмэн болон тодорхой хүчний зарим хэсэгт хариуцлага хүлээх, бэрхшээл учрах явдал гардаг байна. Тийм учраас ардчиллын үнэт зүйлсийн хүрээнд ард түмний дунд зөвшилцөл шаардлагатай болдог.

Үндэсний ашиг сонирхол объектив, субъектив хоёр талтай. Объектив гэдэг нь гадаад, дотоодын бүхий л үйл хэрэгт төр улс, үндэстний оролцоо, хэрэгцээ шаардлага юм. Үүнд: **гадаад орчинд** төр улсын геополитикийн байршил, түүний уламжлалт оршин тогтнохуй, олон улсын харилцаа, аюулгүй байдлын систем дэх үүрэг роль, холбоотны харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа, дэлхийн худалдаан дахь үүрэг роль, оролцоо, **дотоод орчинд** эдийн засгийн хөгжлийн түвшин, тус орон дахь нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтвортой байдал,

энерги, эрчим хүчний хэрэгцээ шаардлага, эдийн засаг, цэргийн потенциал зэрэг орно. Субъектив хүчин зүйлд, юуны өмнө төрийн удирдлагын ертөнцийг үзэх үзэл, үндэсний ашиг сонирхолын дотоод, гадаад хоёр талаас объектив бодит байдлыг хүлээн авах чадвар, шийдвэр гаргах механизм, энэ нь хэр зэрэг үндэсний ашиг сонирхолтой нийцэж байна гэдэгт оршино.

Үндэсний ашиг сонирхолыг хамгаалах, түүнийг эргэлтэд оруулдаг, улс орныхоо аюулгүй байдлыг хангадаг гол субъект нь улс өөрөө байдаг. Үндэсний ашиг сонирхол маань өөрөө нарийн төвөгтэй, урт хугацааны, олон шат дамжлагатай үйл явцын өрнөл бөгөөд эдгээрт нийгмийн, улс төрийн, системийн янз бүрийн субъект оролцдог байна.

Улс орны үндэсний ашиг сонирхолын хэлбэрийг агуулга, мөн чанараар нь доорх байдлаар авч үзэх тохиолдол байдаг аж. Үүнд:

- Төр, улсын мөрөөдлийн чанартай үндэсний эрх ашиг, энэ нь урт хугацааны, биелэгдэх боломж багатай үндэсний ашиг сонирхол,
- Төр, улсын бодит байдлыг харсан үндэсний эрх ашиг, энэ нь богино хугацааны, биелэгдэх боломж өндөртэй үндэсний эрх ашиг сонирхол,
- Төр, улсын тунхаглалын чанартай үндэсний эрх ашиг, энэ нь тунхаглал, албан ёсны мэдэгдэл зэргээр Засгийн газраас албан ёсоор гаргасан үндэсний ашиг сонирхол

зэргийг нэрлэж болох юм. Мөн үүнтэй холбоотойгоор амин чухал эрх ашиг, заавал хэрэгжүүлэх эрх ашиг, үндсэн чухал эрх ашиг гэж бас байдаг байна.

Үндэсний ашиг сонирхолын арга хэрэгсэл: төрт улс өөрийн эрх мэдэлд байгаа бүхий л хүч, хэрэгсэлийг ашиглан ашиг сонирхолоо хамгаалдаг. Улс орны үндэсний эрх ашгийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхийн тулд улс төр, дипломатын, үзэл суртлын, цэргийн хүч, эдийн засаг, техникийн хүчин чадал зэрэг улсын үндсэн хүч чадлыг суурь болгож, олон улсын эрх зүйн хүрээнд явуулах оновчтой ажиллагаа, өөрийн улсын чадавхи, нөөц бололцоо зайлшгүй шаардлагатай болдог байна. Тиймээс үндэсний эрх ашигт заналхийлэх явдал бусад орны зүгээс гарах тохиолдол байдаг учраас үндэсний эрх ашиг маань аюулгүй байдлын баталгааг хангах зайлшгүй шаардлагатай болж ирдэг.

Монгол улсын үндэсний ашиг сонирхолыг авч үзвэл, 200 гаруй жил ноёрхсон манжийн дарлалыг эцэс болгож, эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авч, бүрэн эрхт улсаа байгуулах нь урт хугацааны мөрөөдлийн чанартай үндэсний ашиг сонирхол байж ирсэн. Гэвч хоёр хөршийн бодлогод тааламжтай нөхцөл байдал бий болж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1911 онд Монгол улсын үндэсний тусгаар тогтнолыг зарлан тунхагласан

нь монголын ард түмэнд тохиосон түүхэн үйл явдал байв. Үндэсний ашиг сонирхол бүх ард түмний хүсэл эрмэлзлэлийг илэрхийлсэн урт хугацааны бодлого байх ёстой Гэтэл 1911 оноос хойш монголын төр, засаг, ард түмэнд олон улсын нөхцөл байдал, хоёр хөршийн бодлого зэргээс хамааран үндэсний ашиг сонирхолоо тууштай хамгаалах асуудал хүнд бэрхшээлтэй тулгарч, бүрхэг, ойлгомжгүй, заримдаа тунхаглалын чанартай явж ирсэн гэж хэлэхэд болох юм.

Иймд үндэсний ашиг сонирхолын асуудлаар монголын нийгэм дэх оюутан залуучууд, багш, эрдэмтэд, судлаачид, улс төрчид, гадаад бодлогын салбарынхан гэх мэт хүрээнд болон илүү өргөн олон нийтэд энэ талаар зөв ойлголт өгөх, тэдний санаа бодлыг сонсох, ялангуяа олон улсын харилцаанд манай улсын үндэсний ашиг сонирхолын чиглэл, хандлага өнөөгийн шатанд ямар түвшинд байгаа, түүнийг онол, практик талаас эргэн харах шаардлага байгаа эсэх, олон улсын болон дэлхийн ашиг сонирхолд хэрхэн нийцэж байгаа, улс төр, аюулгүй байдлын, эдийн засгийн, аядуу бодлогын гэх мэт олон ашиг сонирхолоос манай улс алийг нь амин чухал эрх ашгаа гэж тодорхойлох вэ? гэдгийг бид бодолцож, ул үндэстэй хандах явдал чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

## Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы нээлтэд /10.01/ Ерөнхийлөгч Х.Баттулга оролцож хэлсэн үгнээс дор эшлэв. Үүнд:

“... Би Ерөнхийлөгч болсноосоо хойш маш олон улстөрч, улс төр судлалын эрдэмтэдтэй уулзаж, энэ асуудлыг нухацгай авч үзсэний дүнд тогтолцооны хямралыг гэтлэх санал, шийдлүүдийг Эрхэм гишүүд та бүхэнд болон Монголын сонгогчид, нийт ард түмэнд толилуулахаар шийдлээ.

Тогтолцоогоо өөрчлөхгүйгээр юу ч өөрчлөгдөхгүй юм байна. Зүйрлэбэл, бидний хамтран босгосон өрх гэрийн минь суурь, тулгуур баганад алдаа гарч, нурах эрсдэл үүсчихээд байхад бид нурааж, шинээр суурь цутгах, бат бөх тулгуур хийхийн оронд ганц нэг нэмэлт бэхэлгээ хийх, эрсдэл арилсан мэт сэтгэгдэл төрүүлэх гэж өнгөц засвар, будаг түрхэх төдий байдлаар өнөөг хүртэл аргалж иржээ. Одоо аргалж, хуурч хүчрэхгүй хэмжээнд хямрал тулж иржээ. Өрх гэр маань хэдийнээ хазайж эхэлсэн байна.

Хардах, яаран дүгнэхийн оронд та бүгдийг хүлээцтэй хандаж, асуудлыг эрүүл ухаанаар шүүн хэлэлцээсэй хэмээн хүсэж байна. Асуудлын гол нь нийгэмд хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх чадвартай, нийгмийг удирдах, зохицуулах үүргээ хангалттай биелүүлдэг, тэр хэрээр ард түмэн нь ажилтай орлоготой, эрүүл, боловсролтой, амьдралдаа сэтгэл хангалуун, жаргалтай

байх төрийг зохион байгуулах, эмхлэх, ажиллуулах тогтвортой тогтолцоотой болоход л оршиж байгаа.

Монголын төр хариуцлагын хямралд бүрэн өртсөн байна. Дэлхийн банк, бусад байгууллагуудын тодорхойлолтоор “Хариуцлага гэдэг нь шийдвэр гаргагчдаас асуудалд хариу өгөх, шийдвэр гаргах чадвар юм”. Иргэдээс “энэ болохгүй байна” гээд гомдол гарахад төрийн зүгээс хариу өгөх, шийдэл олох чадварыг хариуцлага гэдэг. Гэтэл хариуцлагатай байж, нийгмийн тогтолцоог авч явах ёстой парламент, Засгийн газар зэрэг институци нь өөрсдөө хариуцлагын хямралд орчихоод байгаа нь тодорхой боллоо. Эдийн засаг сайнгүй ядуурал, орлогын тэгш бус байдал газар авсан нь Засаглал муу байгаагийн илэрхий шинж тэмдэг юм.

2018 оны 9 дүгээр сарын 26-29-нд хийгдсэн улс төрийн барометрийн судалгаагаар 10 онооны үнэлгээнээс иргэдийн УИХ-д итгэх итгэл 3.3 хувь, Засгийн газарт үзүүлэх итгэл 4.5 хувь (МЕС) байна. Ард түмний төр засагтаа итгэх итгэл үндсэндээ алга болжээ. Төрийн институцүүд дундаж болон дунджаас доогуур үнэлгээтэй байна гэдэг нь итгэлцлийн хямрал эрсдэлт нөхцөлд байгааг зааж байгаа үзүүлэлт.

Нийгмийн бүх давхарга, улс төрийн бүлэглэл, судлаачдын хүрсэн ойлголт, нэгдсэн цэг нь засаглалын тогтолцоогоо Монгол Улсын хөгжлийн шаардлага, нийгмийн хэрэгцээнд зохицуулан хийх эрс шинэчлэл болоод байна. Үүнийг Үндсэн хуулиар л хийнэ.

УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээний хэлтсээс 2015 онд эрхлэн гаргасан “Монгол Улстай ижил төстэй зарим орны засаглалын болон эрх зүйн тогтолцоо, сонгуулийн хэлбэрийн талаарх мэдээлэл” товхимолд дурдсанаас үзэхэд 1992 оны Үндсэн хуулиараа монголчууд бид түгээмэл бус засаглалын тогтолцоо буюу дэлхийн 196 орноос Болгар, Финланд, Серб, Монтенегро зэрэг 4 оронд л байдаг хагас парламент-хагас ерөнхийлөгчийн холимог засаглалыг авсан нь хөгжлийн мухардалд хүргэснийг одоо харж, мэдэж байна. Ардчилсан шинэ Үндсэн хууль нийгмийн нэг тогтолцооноос нөгөө шинэ тогтолцоо руу хийх шилжилтийг зохицуулахад чухал механизм болжээ. Одоо хөгжлийн шаардлага, нийгмийн хэрэгцээнд зохицуулан шинэчлэх ёстой болж байна. Шинэ Үндсэн хууль, түүнийг батлагсдад “баярлалаа” гэж хэлээд дараагийн шатны Үндсэн хуулиа хэлэлцэх цаг ирлээ.”

**Б.Санжмятав**

МУИС-ийн зөвлөх дэд профессор,  
Олон улсын эдийн засгийн ухааны доктор(Ph.D)

## ХӨГЖЛИЙН БОДЛОГО ПРАГМАТИК БОЛЖ БАЙГАА НЬ

**Х**XI зуунд дэлхийн дулаарал эрчимжиж, баялгийн нөөц хомсдож, шинжлэх ухаан, технологи, тоон/дигитал/ эдийн засаг давшингуй хөгжиж байгаа нь хүн төрөлхтний амьдрах орчинг ихээхэн өөрчилж, мөн олон улсын харилцааны тогтолцоонд хүчний харьцаа өөрчлөгдөх хандлага лавширч, түүнийг дагаад хүн төрөлхтний үнэт зүйлсүүд ч шинэчлэгдэж эхлээд байна. Эдгээр шинэ нөхцөл байдал нь улс орнуудын зүгээс хөгжлийн бодлогоо эргэн харж өөрчлөлт оруулах, урт хугацаанд бодлогоо төлөвлөх, үндэсний хөрсөнд буусан прагматик<sup>1</sup> бодлогыг хэрэгжүүлэхэд хүргэж байна.

Өнөөдөр дэлхийн улс орнууд бүхлээрээ хөгжлийн хэт либераль загвараас татгалзаж, төрийн зохицуулалттай зах зээлийн

эдийн засгийн загварыг сонгох болжээ. Энэ үзэл баримтлалыг 2008 оны 12 дугаар сард Вашингтонд болсон “Их 20”-ийн бүлгийн гишүүн орнуудын дээд хэмжээний анхны уулзалтаас, тухайн үед өрнөдийн зарим орон, олон улсын санхүүгийн институтээс хөгжиж буй орнуудад тулгаж байсан хэт либераль үзэлд суурилсан “вашингтоны зөвшилцөл” нь амьдрах чадваргүй болсныг зарлаж, харин хөгжилд төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн загварыг баримтлахыг зөвлөсөн болно. Ингэхдээ хөгжлийн эл загвар нь үндэстний язгуур эрх ашгийг дээдэлж, үндэсний онцлогийг харгалзан үзсэн байх ёстой гэжээ. Өөрөөр хэлбэл төрөөс улс орноо жолоодон авч явах, хөгжлөө урт хугацаанд төлөвлөх, илүү прагматик бодлого баримталж байхыг анхааруулсан хэрэг юм.

Америкийн эдийн засагч, үйлдвэрлэлийг хөгжүүлэгч Паул Ромер “Endogenous growth theory” буюу “шинэ өсөлтийн онол”-ыг үндэслэж, өсөлтийн эх булаг, загварыг гаднаас

хайх биш, харин дотоодоосоо олох, өнөөгийн дэлхийн, бүс нутгийн хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээ, хангамжийн сүлжээнд хамрагдах, улмаар хүнээ хөгжүүлэх замаар үйлдвэрлэлд технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан салбаруудад шинэ бүтээгдэхүүн гаргаж ялагч болох бололцоо байгааг харуулсан болно. Нөгөөтэйгүүр дэлхийн эдийн засгийн даяаршил зогсонги байдалд орж, эдийн засгийн хөгжлийн үндсэн хандлага бол бүс нутгийн хэмжээнд худалдаа, эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх явдал болсон тул улс орнууд улам бүр протекционист буюу өөрийгөө хамгаалах бодлогыг баримталж эхлээд байна.

Улс орнууд хөгжлийн өөрийн гэсэн загвар, алсын хараатай болох нь ард түмнийг нэгтгэх, тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд тэдний хүч чармайлтыг төвлөрүүлэх, хязгаарлагдмал нөөц, хөрөнгийг үр ашигтай зарцуулахад туйлын ач холбогдолтой байдаг байна. Хөгжлийн сонгож буй онол,

<sup>1</sup> Прагматизм гэдэг нь практик дээр, амьдрал дээр батлагдсан үнэнийг дагах гэсэн утгатай грек үгнээс гаралтай, гүн ухааны нэг урсгалыг хэлж байна. Монголчуудын хувьд танин мэдэхүйг практикаар шалгаж байж үнэнд тооцдог, тэгээд практикийг үнэний шалгуур болгон ашиглаж ирсэн түүхтэй. Тийм учраас прагматизм нь монголчуудын сэтгэлгээнд ойр, ойлгомжтой байна.

загвар нь улс орны удирдлагаас эхлээд, жирийн ард түмний сэтгэл санааг байлдан дагуулж, шийдвэрлэж буй зорилтын зүй тогтол, сонгож болох зохистой арга замыг тодорхойлон, түүнийгээ ард түмний сэтгэлд буулган ухамсарлуулж өгөх шаардлагатай байдаг байна. Энэ талаар Хятадын дарга Ши Зинпинь Гуандон мужид ажиллах үеэрээ, “Бид эхлээд өөрсдийн тавьж буй зорилтдоо итгэл үнэмшилтэй болж, дараа нь эл зорилтыг хэрэгжүүлэх талаар улс орны хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрсний дараагаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаад арга хэмжээнүүдийг нягт уялдаатайгаар хэрэгжүүлэх ёстой” гэжээ<sup>2</sup>. Ингэж ажилласан зарим жишээг дурдья. АНУ “Америк мөрөөдөл (1931 он)”-ийг, Хятад “Хятадын мөрөөдөл (2012)”-ийг, БНСУ-д хоёр Солонгосыг нэгтгэх “Солонгос мөрөөдөл (2014)”-ийг, Казахстан “Казах мөрөөдөл (2016)”-ийг зарлаж, Хятадын зүгээс 2030 оны түвшинд дунд зэргийн хөгжилтэй орны, 2050 онд өндөр хөгжсөн орны түвшинд хүрэх, Казахстаны зүгээс 2030 он гэхэд дэлхийн хөгжилтэй 30 орны нэг болохоор зорьж байгаага мэдэгдсэн байдаг. Ийнхүү улс орны засгийн газрууд мөрөөдлөө тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх хөгжлийн загвараа бодит нөхцөл, байдалдаа тохируулан сонгож байна.

Улс орнуудын зүгээс хөгжлийн сонгосон загварынхаа

хүрээнд стратегия сонгож, бодлогоо боловсруулахын өмнө **“Grand Strategy”** буюу “олон улсын нөхцөл, байдал”-аа тодорхойлдог ажээ. Эл судалгааны хүрээнд тухайн орноос олон улсын худалдаа, дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь, өөрийн давуу тал, олон улсын хамтын ажиллагааны боломжуудыг юуны өмнө судласны үндсэн дээр хөгжлийн тодорхой бодлогоо боловсруулах ажилд ордог байна. Энэ арга, тактикийг азийн орнууд түгээмэл ашигласан байдаг. Тухайлбал, дэлхийн II дайны дараагаас 1950-аад онд Япон, 1960-аад онд азийн 4 луу болох Гонг Конг, Тайвань, БНСУ, Сингапур, 1980-аад онд Тайланд, Индонези зэрэг азийн 4 бар дээрх судалгаа, анализыг хийснийхээ дараагаар олон улсын худалдаа, хамтын ажиллагааны давуу талыг ашиглан улс орноо хөгжүүлэх стратегийг сонгож авчээ. Энэ практик өнөөдөр улам бүр ач холбогдолтой болж, азийн орнууд өргөнөөр хэрэглэж ирэв.

Азийн орнуудаас сонгон хэрэглэж буй хөгжлийн загваруудаас энд авч үзвэл:

**Mumbai Consensus<sup>3</sup> буюу “Бомбейн тохиролцоо”** нь Энэтхэгийн хөгжлийн загвар болно. Энэтхэгийн Засгийн газар хөгжлийн бодлогодоо, худалдан авах чадвар нь улам бүр нэмэгдэж буй дундаж давхаргыг дэмжиж, үйлдвэрлэгч болгох,

үндэснийхээ үйлдвэрлэлээр дотоодынхоо хэрэгцээг хангах, хүнийг хөгжүүлэх замаар эдийн засагтаа шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх бодлого баримталж байна.

**“Seoul Development Consensus” буюу Сеулийн хөгжлийн тохиролцоо**-нд эдийн засгийн өсөлтийг хангах, ингэхийн тулд дэлхийн, бүс нутгийн хэмжээнд түншлэлийг бий болгон хөгжүүлэх, хөгжлийг бий болгоход хувийн хэвшилд тулгуурлах, хөгжлийн тоглогчид нь хүчээ сарниулахгүйгээр, давхардахгүйгээр зөвхөн өөрийн хувь нэмрээ илүү оруулж чадах чиглэлд хүчээ төвлөрүүлэх, тодорхой үр дүн гарч болох чиглэлд Засгийн газраас анхаарлаа хандуулахыг зааж өгсөн байна. Сеулийн хөгжлийн загвар нь хөгжлийг өөрийн нөхцөл байдалд нийцүүлэх ёстой 6 үндсэн зарчим, 9 тулгууртай.

**“Beijing consensus” буюу “Бээжингийн тохиролцоо”** нь Хятадад үндэсний онцлогтой социализмыг байгуулах загвар болно. Хөгжлийн эл загвар нь төрийн зохицуулалттай, зах зээлийн эдийн засгийн сонгодог нэгээхэн хэлбэр болох бөгөөд бодлогод үндэсний онцлог, нөхцөл байдлыг сайтар тусгасан байхыг шаарддаг болно. Английн эрдэмтэн Joshua Cooper Ramo Хятадын хөгжлийн загварын онцлогийг “байнга шинийг санаачлах, турших замаар өөрийн онцлогт тохирсон арга замыг сонгодог, эдийн засгийн өсөлт нь хөгжлийн цорын ганц шалгуур бус, харин тогтвортой хөгжих, орлогыг

2 Sun Yeli, The Direction, Overall Objective, and Methodology of Comprehensive Deepening the Reform, Qiushi (Journal on China's Governance and Perspectives), Jan-March 2015, Vol 7, N 1, issue N 22, p. 61

3 Улс орнуудын зүгээс өөрийн сонгосон хөгжлийн загвар, энэ хүрээнд хэрэгжүүлэх үндсэн зарчмуудыг тусгасан үзэл баримтлалыг нийтийн тохиролцоо гэж нэрлэж, түүнийг улсынх нь, эсхүл нийслэл, хотын нэрээр ялган нэрлэсэн байгаа болно. БС

шударгаар хуваарилах зэрэг чухал шалгуурууд байдаг” гэж тодорхойлжээ<sup>4</sup>. Түүнийг хөгжиж буй орнууд илүү сонирхон, тодорхой зүйлүүдийг эдийн засгийнхаа удирдлагад авч хэрэглэж байна.

Европын орнуудад социал демократ үзэл, нөлөө, **социал демократ хөгжлийн загвар** ямагт хүчтэй явж ирсэн бөгөөд эдийн засгийн хөгжлийн бодлогод нийгмийн асуудлуудыг анхаарлын төвд байлгаж ирсэн болно.

Улс орнууд хөгжлийн загвараа сонгож, бодлогоо тодорхойлсныхоо дараагаар урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө гарган ажиллаж байгаа нь үр дүнтэй болж байна. Тухайлбал, өнөөдрийн байдлаар ОХУ, Аргентин, Бутан, Хятад, Этиопи, Энэтхэг, Непал, Пакистан, Румынь, БНСУ, Вьетнам, Малайзи, Саудын Арави, Танзани, Пуэрто Рико, Бангладеш, Израйль зэрэг орон 5 жилийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Түүнчлэн дэлхийн томоохон өндөр хөгжсөн орнууд мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг 2035 он хүртэл гаргаад мөрдөн ажиллаж байна.

<sup>4</sup> Joshua Cooper Ramo, “Beijing consensus”, Foreign Policy Review, 2004.

Эдгээр төлөвлөгөөнд оруулж зөв тусгасан нэг арга хэмжээ ч улс орны эдийн засаг, өрсөлдөх чадварт чухал ач холбогдолтой байж болдог байна. Жишээлбэл, Бангладеш улс 1977 онд Өмнөд Солонгосын Дээвүү компанийн шугамаар 130 хүн сургасны дараа хувцас үйлдвэрлэлийн салбарыг амжилттай хөгжүүлж чадсан байдаг. Сургасан 130 хүний 115 нь ажлаасаа гарч шинэ компани байгуулан өрсөлдөж эхэлснээр Бангладеш энэ салбарт дэлхийд тэргүүлэгчдийн нэг болсон туршлага байна<sup>5</sup>.

Дэлхийн улс орнууд, юуны өмнө азийн орнууд өөрсдийн хөгжлийн загварыг сонгох, бий болгохдоо үндэсний язгуур эрх ашигт суурилж, дэлхий, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн хандлага, үндэсний давуу тал, онцлогт тохирч, хөрсөнд буух байдлыг үндэслэдэг болох нь дээр өгүүлснээс тодорхой байна.

Прагматизмыг үндэслэсэн, түүнийг одоо хөгжүүлж буй онолчдын зүгээс улс орны удирдагчдад хандан, “бодитой байгаа боломжоо ашигла, тэр боломж дээрээ түшиглэн дараагийн боломжийг хайж олох хэрэгтэй” гэж зөвлөдөг нь дорнын гүн ухаантай яв цав нийцэж байна. Энэ нь монголчуудын “айлаас эрэхээр авдраа уудал”,

<sup>5</sup> <http://asiafoundation.org/2014/06/25/>

“1000 удаа сонсохоос, нэг удаа үзэх нь дээр”, “нүд, чих хоёрын хооронд 4 хуруу зай бий”, “жор мэдэхгүй эмчээс, зовлон үзсэн эмээ дээр” гэх мэт зүйр үгнүүдийн агуулгатай утга нэг байна гэж хэлж болох юм.

Монгол Улсын хувьд, төр засгийн зүгээс дэлхийн, бүс нутгийн эдийн засаг, интеграцчиллын хөгжлийн хандлага, өөрийн давуу тал, хамтын ажиллагааны бололцоог судлах үндсэн дээр өөрийн хөгжлийн загварыг үндэсний хөрсөн дээр буухаар, прагматик байдлаар тодорхойлон гаргаж, түүнийхээ дараагаар хөгжлийн урт, дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулах, энэ ажлыг эрхлэн гүйцэтгэх хөгжлийн яамыг байгуулах шаардлагатай байна. Бидэнд авах бусад улсын амьдралд батлагдсан туршлага, жишээ олон байна. Ач холбогдлоороо түүнээс дутахааргүй өөр нэг зүйл гэвэл, монголын ард түмний сэтгэл, санааг өөрчилж, тавьж буй зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарлыг төвлөрүүлэх, хүн бүр хувь нэмрээ оруулах эрмэлзлийг бий болгох явдал болно.


# БОЛОВСРОЛ

## 2017 / 2018

Бүх шатны сургуулийг 2017/2018 оны хичээлийн жилд 135.1 мянган суралцагч төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 85.4 мянган сурагч (9 дүгээр ангийг 44.6 мянга, 12 дугаар ангийг 40.5 мянга), мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг 20.5 мянган суралцагч, их, дээд сургууль, коллежийг 29.2 мянган оюутан төгсжээ.

Их, дээд сургууль, коллежийг 2017/2018 оны хичээлийн жилд нийт 29.2 мянган оюутан төгссөн нь өмнөх оноос 5.5 мянга буюу 15.9 хувиар буурчээ. Нийт төгсөгчдийн 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Бүх шатны сургуулийг төгсөгчид, мянган хүн



## НОМЫН ЕРТӨНЦӨӨР



Энэ онд ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн 50 жилийн ойгоо тэмдэглэж буй билээ. Ойдоо зориулж хэд хэдэн эмхэтгэл, ном бүтээсний нэг нь **“Монгол улсын гадаад харилцаа: түүх, орчин үе”** нэрээр хэвлэгдэн уншигчдын гарт очоод нэн удаагүй байна. Манай гадаад харилцаа, дорно дахин болоод олон улсын харилцаа судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн эрдэмтэн мэргэд, судлаачдын бүтээлээс түүвэрлэн шилж эмхэлсэн энэ ном сонирхлын хүрээ өргөн хэн бүхний санд залрах л учиртай хэмээнэ. Х.Б.

📍 Монгол улс, Улаанбаатар хот, СБД,  
МУИС-ОУХНУС V байр 308 тоот

✉ [thinktanks99@gmail.com](mailto:thinktanks99@gmail.com)

☎ 976 99070579

📠 976-11354610

